



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A123

Улаанбаатар хот

Албан хаагчдын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.1 дэх заалт, 6.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын албан хаагчдын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн ахлагч:	Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүн:	С.Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	О.Нямбат	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Энхцэцэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Ундармаа	Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний багийн үнэлсэн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн үнэлгээний 85-100 оноог “Маш сайн”, 70-85 хүртэл оноог “Хэвийн”, 70 хүртэл оноог “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамруулан “Маш сайн” үнэлгээнд нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар, “Хэвийн” үнэлгээнд нэг сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцон урамшуулсугай.

3.Албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан тайланг 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор байгууллагын үнэлгээний багт хүлээлгэн өгөхийг нэгжийн дарга нарт даалгасугай.

4.Байгууллагын үнэлгээний баг нэгжийн дарга нарын баталгаажуулсан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг хянаж 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор дүгнэж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулан танилцуулахыг үнэлгээний баг /Д.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСУХ